

ТАНД НЭГ Л СОНГОЛТ БИЙ! (You have only one choice left)

Нэг бол таньд Хүү бий аль эсвэл үгүй.

Таньд Хүү байвал таньд амь бий.

Харин Хүү байхгүй бол таньд амь байхгүй гэсэн үг.

Гэрчлэл нь энэ байна. Бурхан бидэнд мөнх амийг өгсөн бөгөөд энэхүү амь нь Түүний Хүүгийн дотор байна. (1 Иохан 5:11)

Хүүтэй хүнд амь бий

Бурханы Хүү байхгүй хүнд амь байхгүй. (1 Иохан 5:12)

Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй... (Ром 3:23)

Учир нь би хүлээн авсан дараах зүйлийг та нарт дамжуулсан юм. Энэ бол хамгийн чухал хэрэг байлаа. Судрын дагуу Христ бидний нүглийн төлөө үхсэн... (1 Коринт 15:3)

Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн. (Ром 6:23)

Хэрвээ танд Хүү байхгүй бол таньд нэг л сонголт үлдлээ. Бурханы Хүүгийн дотор буй мөнх амьтай байхын тулд Түүнийг өөрийн амьдралдаа хүлээн ав.

Есүс

– Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно. (Илчлэлт 3:20)

Нэг бол та Түүнийг өөрийн дотор оруул

аль эсвэл үгүй.

Нэг бол та Түүнийг хүлээж ав

аль эсвэл үгүй.

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст
Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв. (Иохан 1:12)

Есүс тэдэнд хандаж

—"Христ зовлон эдэлж, гурав дахь өдрөө үхэгсдээс амилах болно.

Иерусалимаас эхлээд бүх үндэстэнд Түүний нэрээр нүглийн уучлалын гэмшил
тунхаглагдах ёстой" гэж бичигдсэн юм. (Лук 24:46,47)

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний
нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. Хэрэв бид нүгэл
үйлдээгүй гэж хэлбэл, бид Түүнийг худалч болгож байгаа хэрэг бөгөөд бидний
дотор Түүний үг алга. (1 Иохан 1:9, 10)

Бурханы хүслийн дагуух гашуудал нь үл харамсах гэмшлийг бий болгон авралд
хүргэдэг аж. Харин ертөнцийн гашуудал нь үхлийг бий болгодог. (2 Коринт
7:10)

Та Түүнийг өөрийн амьдралдаа хүлээн авмаар байвал дараах энгийн залбирлыг
хэлээрээ:

Эзэн Есүс ээ, би гэмтээ гэдгээ хүлээн зөвшөөрж байна. Би Таны өмнө бүх гэм
нүглээ дэлгэж байна. Мөн бүх гэм нүглийнхээ төлөө Таны өмнө гэмшиж байна.
Би тэдгээрийг мартан, тэдгээрээс эргэхийг сонгож байна. Би Таныг өөрийн
амьдралдаа Аврагч хэмээн хүлээн авч байна. Энэ цаг мөчөөс эхлэн Та миний
амьдралын Эзэн мөн Багш байх болтугай. Есүсийн нэр дээр, Амээн.

Огноо _____

Гарын үсэг _____

Таньд асуух зүйл гарвал дараах хаяг руу хандаарай:

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Итгэдэг хүн мөнх амьтай. (Иохан 6:47)

Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг
та нарт эдгээр зүйлийг бичсэн. (1 Иохан 5:13)

Тиймээс та нар Эзэн Христ Есүсийг хүлээн авсан шигээ Түүн дотор алхахдаа, заалгаж байснаараа Түүн дотор бат үндэслэгдэн, байгуулагдаж, итгэл дотроо баталгаажин, талархлаар бялхагтун. (Колоссай 2:6,7)